- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
ЗДТГ-ын дарга _____ С.Дэлгэржаргал
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

1919100026 № 9022732

Ёс зүйн дэд хорооны дарга
Нягтлан бодогч _____ Д.Мөнхбаясгалан
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
ХЖДҮХАХМэргэжилтэн _____ Б.Алтанзул
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 12 сарын 30

Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

ХОНГОР СУМЫН ЗДТГ-ЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
"ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Дархан-Уул аймгийн Хонгор сумын засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 01 сарын 13-ний өдрийн А/03 тоот "Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай " тушаалаар дараах бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны дарга: Э.Номин /Төрийн сангийн мэргэжилтэн/ Нарийн бичиг: Ш.Нурсауле /1 дүгээр багийн зохион байгуулагч/ Гишүүд: С.Амаржаргал /Архив, бичиг хэргийн ажилтан/ Б.Айсоуле /ХЖДҮХАХ мэргэжилтэн/ Д.Өөдөс /Татварын орон тооны бус байцаагч/
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
1.Ёс зүйн хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн төлөвлөгөө боловсруулан батлан ажиллаж байна. 2.Байгууллагын удирдлага Ёс зүйн хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээний хуудас"-аар 35 албан хаагчдаас ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийж ажилласан. 3. Хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын мэдээллийн цагаар 2 удаа сургалт зохион байгуулсан давхардсан тоогоор нийт 48 албан хаагч оролцсон. 4."Байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулах" ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах тухай " сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Мөн энэ үеэр "Амгалан заяа" ХХК- ийн эмийн санч Б.Будалхаянтай хамтран албан хаагчдыг витаминжуулах ажлыг хийж хэрэгжүүлэн ажилласан. 5.Төрийн албан хаагчийн тангарагыг 30*70 хэмжээтэй, 11 ш хэвлэмэл хавтанд хэвлүүлэн албан хаагчдын өрөөнд тус тус байршуулсан. Уг ажлыг хийхэд 594,000 төгрөгийн зардал гарсан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Scanned with CamScanner

6.Ёс зүйн хэм хэмжээний талаарх зөвлөмжийг 35 албан хаагчид хүргүүлсэн байна.

7.Шинээр томилогдсон 3 албан хаагчид 8 цагийн сургалтыг зохион байгуулж ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулан чиглүүлэн ажилласан.

8.Ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавх бэхжүүлэх чиглэлээр 3 удаагийн сургалтад бүрэлдэхүүнээрээ хамрагдсан.

9. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийхэд зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан хаагч байгаагүй учир ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулаагүй.

10. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй тул ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт хөтлөгдөөгүй болно.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

- ✓ Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол гараагүй тул Ёс зүйн хорооны дүгнэлт болон томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй болно.
- ✓ Төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр тайлант хугацаанд гараагүй тул байгууллагын цахим хуудсанд байршуулаагүй.
- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т "Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх" гэж заасныг тайлант хугацаанд 1 удаа хэрэгжүүлж Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг, гишүүд нь хуульд заасны дагуу 3 дугаар улиралд урамшуулалд хамрагдсан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол тайлант хугацаанд ирээгүй тул дүгнэлт, шийдвэр гараагүй болно.
- ✓ Улирлын тайлан мэдээг хугацаанд нь 4 удаа салбар зөвлөлд хүргүүлсэн байна.
- ✓ Дэд хорооны төлөвлөгөө, тайланг хугацаанд гаргаж хүргүүлэн ажилласан.
- ✓ Хонгор сумын соёлын төвөөс ирүүлсэн 12 тоот албан бичгийн хүрээнд Соёлынтөвийн 5 албан хаагчид "Ёс зүйн дэд хорооны Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах тухай" сургалт зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажилласан.
- ✓ Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргын Тамгын газрын чанарын менежментийн тогтолцооны хүрээнд иргэд, үйлчлүүлэгчийн санал гомдлыг хүлээн авч барагдуулах, сэтгэл ханамжийг тодорхойлох журмын хавсралтын 5 санал асуулгаар 108 иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллалаа. Иргэд албан хаагчдын ур чадварыг сайжруулах тал дээр анхаарч ажиллахыг санал болгосон бөгөөд албан хаагчдыг харилцаа, хандлага ёс зүйн талаар сургалт, мэргэшүүлэх сургалтад хамруулах; Судалгааны үр дүнд дэвшилттэй болон дутагдалтай талыг тодорхойлж ирэх жилийн төлөвлөгөөнд тусган ажиллана.

Scanned with CamScanner

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна.	Санхүүгийн эх үүсвэр дутмагаас болж Нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулахад хүндрэлтэй байдаг.
Санал:	
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлсэн Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг, гишүүд нь хуульд заасны дагуу урамшуулалд улирал бүр хамрагдах.	

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Хонгор сум ЗДТГ-ын дарга — /Албан тушаал/ — /Гарын үсэг/ — Ч. Мөнхтуяа. /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

Төрийн албан хаагч — /Албан тушаал/ — /Гарын үсэг/ — Д. Ууганаа /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

1-р багийн засаг дарга — /Албан тушаал/ — /Гарын үсэг/ — Ш. Нүргаяа /Гарын үсгийн тайлал/

Огноо: ...2025... оны .12 сарын .30

Орхон

суд

МТХ.

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Шарын гол сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 1 албан хаагчид хамааралтай гомдлыг 2 албан хаагчаас ирүүлсэнтэй холбогдуулан тус хороо хуралдаж холбогдох албан хаагчаас нэмэлт тодруулга авч хугацаанд нь шийдвэрлэж дүгнэлт гаргасан. Дүгнэлтэд тухайн албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргасанд тооцсон бөгөөд холбогдох албан хаагчид болон ЗДТГ-ын даргад албан бичгээр хүргүүлсэн. Уг дүгнэлтийг үндэслэн тус албан хаагчид Засаг даргын Тамгын газрын дарга Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлээр сонсох ажиллагаа явуулж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16.1.2 дахь заалтыг үндэслэн өөрт нь ганцаарчилан сануулах хэлбэрээр ёс зүйн хариуцлага ногдуулсан. Гарсан зөрчлийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын нийт 30 албан хаагчдад дунд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаар сургалтыг 2 удаа зохион байгуулсан.





Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага, хориглох зүйлсийн жагсаалтыг хэвлэж албан хаагч бүрийн ширээн дээр иргэд болон албан хаагчийн нүдэнд харагдахуйц газар байршуулсан.





Мөн албан хаагчдыг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Үүнд: Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага, хориглох зүйлсийг мөрдлөг болгох, Төрийн албанд ёс зүйг эрхэмлэн ажиллаж байгаа албан хаагчдыг үнэлж, урамшуулах замаар бусдад үлгэр дуурайлал болгох, Төрийн албан хаагчдын ёс зүйг сайжруулснаар төрийн байгууллагад иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, Төрийн албанд ёс зүйтэй, шударга байдалд чиглэсэн хандлага, үйл

ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын улс төрийн, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан хаагчид /босоо удирдлагатай/ бүгдийг хамруулан “БИ ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” 11 долоо хоногийн аян зохион байгуулж 1.Цаг баримтлал, цагийн менежмент, 2.Хувцаслалт, 3.Түрүүлж мэндлэх, эерэг харилцаа хандлага, 4.Ажлын байран дээр болон олон нийт, цахим орчинд ёс бус үг хэллэг хэрэглэх, иргэдтэй болон бусад албан хаагчидтай соёлч боловсон харьцсан эсэх, 5.Иргэд болон байгууллагын албан хаагчдын хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгсөн байдал гэсэн таван шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүрийн Баасан гаригт албан хаагчдаас санал авч тус аяныг дүгнэж нийлбэр оноогоороо өндөр оноо авсан 3 албан хаагчийг шалгаруулж урамшуулсан.

“Түрүүлж мэндэлье” аяныг ажлын 5 өдөр зохион байгуулж байгууллыг албан хаагчдад 5 өдрийн турш албан хаагчдийн дунд гэнэтийн таатай уур амтсгал бүрдүүлж ажилласан.







Монгол бахархлын өдөр, Улс тунхагласны 101 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын дунд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, түүх, танин мэдэхүйн чиглэлээр “Алтан хонх” хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулсан.

Мөн Дэлхийн ёс зүйн өдөрт зориулж албан хаагчдын дунд ёс зүйн модоо чимэглэе, ёс зүй гэж таны бодлоор юу вэ сэдэвт чөлөөт, санал бодлоо илэрхийлэх арга хэмжээ зохион байгуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

“БИ ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” 11 долоо хоногийн аян зохион байгуулж, үр дүнг нэгтгэн Монгол Улсын төрийн албаны өдөр албан хаагчдын олонхын санал авсан 3 албан хаагчийг шагнаж урамшуулсан.

1-р байр Өргөмжлөл, Манжуур аялах эрхийн бичиг
2-р байр Үндсэн цалингийн 30 %-тай тэнцэх мөнгөн урамшуулал
3-р байр 5 хоногийн цалинтай чөлөө


“Би ёс зүйтэй төрийн албан хаагч” уралдааны ШИЛДЭГ-10

Д/д	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Авсан санал
1	Б.Шүрэнцэцэг	Үйлчлэгч	119
2	Ц.Мөнхбаяр	ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн	108
3	Ж.Алтанчимэг	ХЖДҮАХ мэргэжилтэн	103
4	Ү.Номин-Эрдэнэ	Олон нийттэй харилцах ажилтан	92
4	Ж.Баттулга	Татварын улсын байцаагч	92
5	Г.Солонго	ИТХ-ын нярав, архив бичиг хэрэг	91
6	Г.Амаржаргал	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	90
7	Б.Аззаяа	Улсын бүртгэгч	88
8	Ц.Баярмаа	ХЭХАХ мэргэжилтэн	83
9	Б.Анар	ТОТБ байцаагч	81
10	С.Мариягул	Төрийн сангийн мэргэжилтэн	80

“Би ёс зүйтэй төрийн албан хаагч” уралдааны санал асуулгын дүн

ИТХурал, ЗДТГазар 2025.07.03





Дэлхийн ёс зүйн өдрөөр “Ёс зүйн мод”-ыг хамтдаа бүтээж, мөн өдөр төрийн албаны хувцаслалтаараа бусдадаа үлгэр дуурайлал болсон эрэгтэй, эмэгтэй нэг нэг албан хаагчийг урамшуулж талархал, дурсгалын зүйл гардуулсан.









Монгол бахархлын өдөр, Улс тунхагласны 101 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын дунд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, түүх, танин мэдэхүйн чиглэлээр “Алтан хонх” хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулсан.





Дээрх тэмцээн, арга хэмжээнд тэргүүлсэн албан хаагчийг урамшуулах дурсгалын зүйлсийг Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга нар ивээн тэтгэж хамтарч ажилласан.

Ёс зүйн дэд хорооны танилцуулга, хууль, мэдээ мэдээлэл, санал хүсэлт авах хайрцаг бүхий самбарыг байршуулж иргэдийг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.




2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/76 дугаар тушаалаар сумын ИТХ, ЗДТГ-ын 5 албан хаагчаас бүрдсэн ёс зүйн дэд хороог байгуулан ХНУМТ цахим системд дарга, гишүүдийн мэдээллийн оруулсан. Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн, нарийн бичгийн дарга солигдож эцсийн байдлаар 2025.09.18-ны өдрийн А/58 дугаар тушаалаар дэд хорооны дарга, гишүүнийг шинэчлэн баталсан. Нарийн бичиг шинэчлэгдэж цахим системд нэвтрэх эрхээ авахаар албан бичиг хүргүүлээд байна.

2025 онд авч хэрэгжүүлэх 3 зорилт, 16 арга хэмжээ бүхий жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж уг төлөвлөгөөний дагуу сургалт, нөлөөллийг ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Тус дэд хороо нийт 7 удаа хуралдаж 2 удаагийн сургалт, 5 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулсан.

Ёс зүйн дэд хорооны гишүүдийг мэдээллээр хангах, чадавхжуулах зорилгоор Дархан-Уул аймагт Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ 2 өдрийн хэлэлцүүлэгт хамруулсан

Шарын гол сумын засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо гэсэн фэйсбүүк пэйж хаягаар зохион байгуулсан үйл ажиллагаа бүрийг нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.



Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Хамт олны уур амьсгал, нөлөөллийн үйл ажиллагааны чанар сайжирсан. Удирдлагууд хорооны үйл ажиллагааг бүх талаар дэмжиж шаардлагатай тохиолдолд ажлаас түр чөлөөлдөг. Ирсэн гомдол, зөрчлийн тоо өмнөх оноос 1-ээр буурсан.	Хуулийн заалтыг хэрэглэхэд хэт ерөнхий ойлгомжгүй байсан. Нарийн бичгийн дарга солигдсонтой холбогдуулан цахим системд нэвтрэх эрхийг шинэчлэх тухай албан хүсэлтээ Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.

Санал:

1. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг урамшуулах асуудлыг шийдвэрлэх
2. Хуулийн хэрэглээтэй холбоотой Ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалтаар хангах

Шалгах хэсэг:

☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур

үзүүлэлтэд нийцүүлэн батлсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх

☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга Г.Шинэхүү

Албан тушаар Гарын үсэг Гарын үсгийн талбайр

Ёс зүйн дэд хорооны дарга Б.Оюунжаргал

Албан тушаар Гарын үсэг Гарын үсгийн талбайр

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Халиунаа

Албан тушаар Гарын үсэг Гарын үсгийн талбайр

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Хонгор сум

НЭГ. Товч танилцуулга
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Ёс зүйн хороог 3 хүний /ИТХ-ын төлөөлөгч/ бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
1.Ёс зүйн хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн төлөвлөгөө боловсруулан батлан ажиллаж байна. 2.Байгууллагын удирдлага Ёс зүйн хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээний хуудас"-аар ажлын албаны хаагчдаас ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийсэн. 3.ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны албан хаагчдад тус хуулийг сурталчилан таниулах сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Мөн ИТХ-ын төлөөлөгчид болон ажлын албаны албан хаагчдад ёс зүйн манлайлал, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилгоор Удирдлагын академийн богино хугацааны захиалгат 16 цагийн сургалтад 2025 оны 10 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд хамруулсан. (ИТХ-ын 25 төлөөлөгч, ажлын албаны 3 албан хаагч нийт 28 хүнийг тус сургалтуудад бүрэн хамруулсан.) 4.Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг ИТХ-ын төлөөлөгч, ажлын албаны албан хаагчдад тараан өгч танилцуулж, сумын төр, төсвийн байгууллагын удирдлагуудад төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллан хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, сургах, хөгжүүлэх, үнэлж дүгнэхэд тооцдог байхыг уриалсан. 5.Ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийхэд зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан хаагч байгаагүй тул ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулаагүй. 6.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол тайлант хугацаанд ирээгүй тул ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт хөтлөгдөөгүй болно.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
- Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол гараагүй тул Ёс зүйн хорооны дүгнэлт болон томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй болно. - Төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр тайлант хугацаанд гараагүй тул байгууллагын цахим хуудсанд байршуулаагүй. - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т "Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх" гэж заасныг тайлант хугацаанд хэрэгжүүлээгүй. Учир нь тус сумын ИТХ-ын ажлын алба нь 4 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа тул Ёс зүйн дэд хороо байгуулах боломжгүй байна.
2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол тайлант хугацаанд ирээгүй тул дүгнэлт, шийдвэр гараагүй болно.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Байхгүй	Ёс зүйн дэд хороо байгуулах боломжгүй байна.
Санал: Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4-т “40 ба түүнээс цөөн төрийн албан хаагчтай байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 3 гишүүн, 41-90 бол 5 гишүүн, 91-ээс дээш бол 7 гишүүнтэй байна” гэж заасан. Тус сумын ИТХ-ын ажлын албаны орон тоо 4 албан хаагчтай тул хууль, журмыг хэрэгжилтийг ханган 3 гишүүнтэй Ёс зүйн дэд хороо байгуулан ажиллахад боломжгүй байна. Иймд журамд 5 ба түүнээс цөөн албан хаагчтай төрийн байгууллагад Ёс зүйн дэд хороотой байх эсэх тухай зохицуулалтыг тусгаж нэмэлт өөрчлөлт оруулах саналтай байна.	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ИТХ-ЫН ДАРГА Ш.БАТ-ӨЛЗИЙ

ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА Х.ХАШ-ЭРДЭНЭ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.ОДОНТУЯА

Огноо: 2025..... оны ..12 сарын ..24...



Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын
01- ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

НЭГ .Товч танилцуулга
Байгаль орчны газар нь 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/7 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 гишүүнтэйгээр байгуулан одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Нийт 15 албан хаагчтай, үүнээс төрийн захиргаа 11, төрийн үйлчилгээний албан хаагч 4 байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: Хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлан эрсдэлийг бууруулах, сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, ёс зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэснээр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн хамт олон болох зорилт тавин ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд шинээр ажилд орсон 1 албан хаагчийн ажлын байрны эрсдэлийг үнэлж, ярилцлага хийж, ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг авч, 1 албан хаагчийн ёс зүйн зөрчилд хариуцлага ногдуулсан. 2025 онд хэрэгжүүлэхээр 10 ажил арга хэмжээг ёс зүйн дэд хороогоор хэлэлцэн баталж, 4 удаагийн сургалт, байгууллагын дотоод сүлжээ, албан хаагчдын фейсбүүк группэд ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрэм журам, зураг хуудсыг 10 гаруй удаа байршуулж нөлөөллийн ажлыг хийсэн.
2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Байгаль орчны газрын дарган тушаал 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/7 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 гишүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.
2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа: 2025 оны 01 сарын 17-ны өдөр ёс дэд хорооны хурлаар хэлэлцэж 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр жилийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлэх 4 удаагийн сургалт явуулснаас “Ёс зүй, Мэндлэх хүндлэх ёс, Монголчуудын ёс заншил” сургалт, өдөрлөг” зохион байгуулж, ёс зүйн өдөрлөгт амжилттай 3 албан хаагчийг 3 хүртэлх ажлын өдрийг зайнаас ажиллахаар чөлөө олгож урамшуулсан. Мөн байгууллагын дотоод сүлжээ, албан хаагчдын фейсбүүк группэд ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрэмж журам, зураг хуудсыг 10 гаруй удаа байршуулж нөлөөллийн ажлыг хийсэн. Ёс зүйн хорооны нарийн бичгийн дарга А.Аззаяа нь АТГ-ын “Авилгаас ангид ёс зүйтэй төрийн албан хаагч” мэтгэлцээний тэмцээнд орж тусгай байр эзэлж, батламж авсан.

Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь шинээр ажилд орсон 1 албан хаагчийн ажлын байрны эрсдэлийг үнэлж, ярилцлага хийж, ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг авч, 1 албан хаагчийн ёс зүйн зөрчилд хариуцлага ногдуулсан. Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгавар, Төрийн албаны зөвлөлийн 268 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 24-р хуралдааны тэмдэглэл, Төрийн албаны салбар зөвлөлийн 2025 оны 156 тоот “Ёс зүй, сахилга , хариуцлагыг сайжруулах тухай” , газрын ёс зүйн дэд хорооны 2025 онд хийсэн ажлын тайланг газрын 342 тоотоор ТАСЗ-д хүргүүлсэн.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн “Төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлага ёс зүй” 16 цаг 2 кр сургалтад хамрагдаж сертификат авсан. Мөн дэд хорооны гишүүн А.Аззаяаг Эрхчзүйч мэргэжлээр бакалаврын түвшний сургалтад суралцаж 120 кр цаг амжилттай цуглуулахад байгууллагын зүгээс чөлөө олгож дэмжин ажиллаж байна.	Төсвийн хэмнэлтийн тухай хууль, журамтай холбоотойгоор ёс зүйн дэд хорооны мөнгөн урамшуулал шийдвэрлэгдээгүй.
Санал: Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:

Дарга /Г.Батбаяр/

Ёс зүйн дэд хорооны дарга:

Ахлах мэргэжилтэн /Ж.Болдбаатар/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:

Мэргэжилтэн /Я.Батбилэг

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Нэг . Товч танилцуулга

Байгууллагын ёс зүйн дэд хороог Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/30 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан байна.

Тус газар нь аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/316 дугаар захирамжаар 30 орон тоотой батлагдсан бөгөөд 2025 онд 28 албан хаагч ажиллаж хүний нөөцийн бүрдүүлэлт 93,3 хувиар хэрэгжсэн байна. Авлигатай тэмцэх газраар тайлант жилийн хугацаанд хөрөнгө орлогын урьдчилсан хянуулсан 3 буюу 100%, ХАСХОМ-ийг тайлагнах 3 албан хаагч буюу 100%, хуулийн тогтоомжийн зөрчилтэй томилогдсон 0 зөрчлийг 100 хувь хэрэгжлээ. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тайлбарыг 3 албан хаагч гаргаж системд хугацаанд нь бүртгэл үүсгэсэн байна.

Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэжилт

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар, хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад чиглэсэн бөгөөд 2025 онд сургалт, семинар, вебинар, гарын авлага, уралдаан, хэлэлцүүлгийн арга хэмжээ зохион байгуулж нийт 24 албан хаагч хамрагдсан. Мөн ёс зүйн хяналт, үнэлгээг хийж, дүн шинжилгээ гаргасан нь мэдлэгийн түвшин нэмэгдэж, ёс зүйн зөрчил буурах үр дүн үзүүлсэн. Цаашид хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгааны арга хэмжээг нэмэгдүүлэх, хяналт үнэлгээг тогтмол хийх нь зөв гэж дүгнэлт гарсан.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Томилох эрх бүхий албан тушаалтнууд нь ёс зүй, сахилга хариуцлагын өндөр стандарт тогтоож, ажилтнуудыг ёс зүйтэй ажиллахад манлайлж, зөв үлгэр дуурайл үзүүлсэн бөгөөд шийдвэр гаргах, албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа ил тод, шударга, хуулийн дагуу ажиллаж, ёс зүйн зөрчил гаргах эрсдлийг бууруулах чиглэлээр удирдлагаар тодорхой арга хэмжээ авч ажилласан.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Тус газрын Байгууллагын ёс зүйн дэд хорооны жилийн ажлын төлөвлөгөөг 2 зорилт 5 арга хэмжээ төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 96 хувь хэрэгжсэн. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос санаачлан “Grow” аргачлалыг ашиглаж, нийт 24 албан хаагчдад сургалт зохион байгуулж, судалгаа авсан. Үүний үр дүнд албан хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, зөвлөгөө өгч соён гэгээрүүлэх үйл ажиллагаа амжилттай явагдсан. Мөн Ёс зүйн тухай хуулийг сурталчлах постер байршуулж, албан хаагчдын дунд талархал, гомдол, хүсэлтийг хүлээн авах нээлттэй хайрцгийг ажиллуулснаар одоогийн байдлаар ирсэн гомдол, зөрчил гараагүй байна

Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хамгийн их санал гарсан ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнд албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгслээр хангах, 10 албан хаагчийн компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, 28 албан хаагчийг 4,4 сая төгрөгийн бэлтгэлийн хувцсаар 100 хувь хангах, хүндийн өргөлтийн танхим, жүдо бөх, сагсан бөмбөг, волейболын багш нарын өрөө, шат, амралтын өрөөний ариун цэврийн өрөөг иж бүрэн засварлах, харуулын сандлыг шинэчлэх зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудыг 100 хувь гүйцэтгэж, албан хаагчдын ажлын нөхцөл, сэтгэл ханамжийг сайжруулсан.	
Гарсан үр дүн:	**Бэрхшээл**
Албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн ойлголтыг хэлтэс бүрт тусгайлан зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, санал асуулгын үр дүнд нийт 25 албан хаагч хамрагдаж, хууль эрх зүйн мэдлэг нь дээшилж, ойлголтын зөрүү арилсан. Энэхүү арга хэмжээ нь албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын талаарх ойлголтыг нэгэн жигд түвшинд хүргэж, зөв практик үйлдлийг төлөвшүүлэх, харилцан туршлага солилцох боломжийг нэмэгдүүлсэнээр байгууллагын ёс зүйн соёлыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн.	Хувь хүний хууль, дүрэм журмын мэдлэг дутмаг байдлыг нөхөн, ёс зүйг өдөр тутмын ажилд хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой ойлголт авсан ч зарим албан хаагчдын хувийн хандлага, хэвшмэл үзэл, мэдээлэл солилцооны дутагдал нь байгууллагын ёс зүйн соёл, сахилга хариуцлагын түвшинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
Санал: Бидэнд одоо тулгамдаж буй хамгийн чухал шаардлага нь асуудлыг хүнээс салгаж харж, шийдэл төвтэй харилцааг төлөвшүүлэх явдал юм. Энэ хүрээнд бие биенээ сонсож, өөр өнцгийг хүндэтгэх соёлыг хөгжүүлэх, хэлсэн үгийг агуулга, шийдлийн хувьд үнэлэх хандлагыг хэвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Бид бие биенийгээ бус, шийдэл, үр дүн рүү чиглэсэн шүүмжлэлтэй, ажил хэрэгч сэтгэлгээг хөгжүүлснээр албан ёсны мэргэжлийн хүрээнд илүү оновчтой, үр дүнтэй ажиллах боломж бүрдэнэ гэсэн саналыг дэвшүүлж байна.	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА А.АМАРАА

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Б.ХОВОР-ЭРДЭНЭ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ш.СЭЛЭНГЭ

Орон нутгийн өмчийн газрын
2025 оны 12. дугаар сарын 10.-ны өдрийн
536. тоот албан бичгийн хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын Ёс зүйн дэд хороо бүтэц бүрэлдхүүнийг Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд нийцүүлэн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/15 дугаар тушаалаар батлуулж 3 орон тооны бус гишүүнтэйгээр байгуулсан болно. Тус газрын үйл ажиллагааны онцлогт тохируулан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/23 тушаалаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 2025 онд тус газрын албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол байхгүй бөгөөд энэ тухай мэдээ тайланг Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хуулийн хугацаанд 2 удаа хүргүүллээ. Ёс зүйн дэд хорооны хурлыг 2 удаа (Ёс зүйн дэд хорооны даргыг томилох, Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийг томилох) зохион байгууллаа.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Газрын албан хаагчдын ёс зүйн зүйн зөрчилд өртөх эрсдлийг тогтоох, ёс зүйн хандлагыг тодорхойлох, цаашид үүсч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор харилцагч байгууллагуудын дунд Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын ёс зүйн талаарх судалгаа явуулж, үр дүнг албан хаагчдад танилцуулж, цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг өгч ажиллалаа.(Тайлангийн хавсралт-1) Албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ёс зүйн дэд хорооноос 3 удаагийн(Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Шинээр ажилд орсон Төрийн албан хаагчид Төрийн албан хаагчид Ёс зүйн тухай хуулийн танилцуулах сэдэвт) сургалтуудыг зохион байгууллаа. Мөн Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадвахжуулах зорилгоор Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, ёс зүйн нийтлэг шаардлага, хэмжээ хэмжээний тухай ойлголт, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хүлээлгэх хариуцлага зэрэг мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллалаа.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

1. Тус газрын долоо хоног бүрийн даваа гаригт зохион байгуулагддаг Дотоод хурлын үеэр албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд сахиж, ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллахыг сануулж, уриалж ажиллалаа. 2. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой гарч байгаа албан бичиг, тайланг нийт 2 удаа хянаж ажиллалаа. 3. Албан хаагчдыг бусад байгууллагаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хамрагдах боломжоор хангалаа. 4. Ёс зүйн дэд хорооны тайланг хагас жил тутам хянаж ажиллалаа.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Ёс зүйн дэд хороо 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилт, 12 ажил арга хэмжээ төлөвлөж үүнээс 12 ажил арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна (Тайлангийн хавсралт-2). Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хууль, журамд нийцүүлэн томилж Ёс дэд хорооны хурлыг Ёс зүйн дэд хорооны даргыг томилох, Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийг томилох зорилгоор 2 удаа зохион байгууллаа. албан хаагчдад Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Ёс зүйн нийтлэл хэм хэмжээ, Ёс зүйн зөрчил зэрэг сэдвээр сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, шинээр ажилд орсон төрийн албан хаагчид Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль тогтоомжийг танилцуулах сургалтыг зохион байгууллаа. Бусад газраас зохион байгуулсан сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүд идэвхтэй хамрагдаж, Бүсчилсэн хөгжил Төрийн албаны манлайлал сэдэвт Төрийн албан хаагчийн Ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг, Төрийн албаны салбар зөвлөл, Канад-Монголын мэрит төслийг баг хамтран зохион байгуулсан “Ёс зүйт манлайлал” сэдэвт цахим сургалтад тус тус хамрагдлаа. 2025 онд Орон нутгийн өмчийн газарт албан хаагчдад холбогдох ёс зүйн зөрчилтэй гомдол мэдээлэл ирээгүй бөгөөд энэ тухай мэдээ, тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хуулийн хугацаанд 2 удаа хүргүүллээ.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
-Эерэг уур амьсгалтай ажлын орчин бүрдсэн -Нийт албан хаагчид ёс зүйн хэм хэмжээний нийтлэг шаардлагын тухай ойлголттой болсон -Ёс зүйн зүйн зөрчил гаргаагүй	-
Санал:	
-	

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Дарга / Д. Бат-Эрдэнэ

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

ОУХХАМ / Б. Баасанхүү

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ХХШҮДАМ / Төгөлдөр / З. Төгөлдөр

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

2025 оны 12 сарын 30 өдөр

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР
2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу байгууллагын Ёс зүйн дэд хороог Газрын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Мал эмнэлгийн газар нь бүтэц орон тооны хувьд төрийн захиргааны 10 албан хаагч, төрийн үйлчилгээний мэргэжлийн 8 албан хаагч, төрийн үйлчилгээний 1 албан хаагч нийт 19 албан хаагчтай.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрийн дагуу байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг 3 зорилт 8 арга хэмжээтэй батлуулсан. Тус төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 6 үзүүлэлтийн дагуу 4 оноо буюу 100 хувьтай үнэлэгдсэн.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Байгууллагын ёс зүйн дэд хороонд 2025 оны жилийн эцсийн байдлаар алба хаагчдаас гомдол, мэдээлэл ирүүлээгүй бөгөөд 3 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд 2 оноо буюу 66,6 хувиар үнэлэгдсэн. Энэ нь 3 дахь шалгуур үзүүлэлт буюу Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдлын үнэлгээ 0 хувь байсан тул 2 оноо авч 66,6 хувьтай үнэлэгдсэн байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Дэд хороо нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 4 удаа хуралдаж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор албан хаагчдад зориулан явуулах сургалт, мэдээлэл, албан хаагчдаас авах санал асуулга, дүн шинжилгээг боловсруулах, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг асуудлаар хэлэлцэн шийдвэрлэж ажиллав. Төрийн албаны зөвлөл болон Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан ёс зүйн сургалтад давхардсан тоогоор 21 алба хаагч хамрагдсан. Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар албан хаагчдад сургалт хийж мэдээлэл хүргэсэн. Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрмийн сургалтыг явуулснаар байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хэрхэн хянан шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл, төрийн

захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, төрийн албан хаагч Төрийн албаны тухай хууль болон энэ хууль дүрмээр хүлээсэн хэм хэмжээг хэрхэн сахин мөрдөж ажиллах тухай мэдлэг мэдээллийг өгсөн.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн зөрчилгүй ажиллах тухай арга хэмжээг төлөвлөн 5 удаагийн сургалтыг зохион байгуулсаны үр дүнд Мал эмнэлгийн газрын алба хаагчдад 2025 онд Ёс зүйн зөрчил илрээгүй.	Байхгүй.
Санал: Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд бүртгүүлэх хүсэлтийг Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн боловч 2025 оны жилийн эцсийн байдлаар эрх нээгдээгүй тул тус системд хандах боломжгүй байна. Иймд хандах эрхийг яаралтай нээлгэх саналтай байна.	

Шалгах хэсэг:

- ☑ "Ес зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Газрын дарга Б.Нямдорж
/Албан тушаал/ Гарын үсэг Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
Мэргэжилтэн Н.Баасансүрэн
/Албан тушаал/ Гарын үсэг Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Улсын байцаагч Б.Мөнхдаваа
/Албан тушаал/ Гарын үсэг Гарын үсгийн тайлал/

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

НЭГ.Товч танилцуулга
2025 онд тус байгууллагын албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг зөрчсөн, нэр хүндийг унагасан аливаа үйлдэл гаргаагүй, гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна. Албан хаагчдын ёс зүй, хариуцлагын байдлыг тодорхойлох зорилгоор 2025 онд шалгалтад хамрагдсан байгууллагуудаас хэрэглэгчийн судалгаа авч, дүгнэлт гаргасан. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээллийг цахим системд бүртгэсэн. Газрын дарга төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд баримталж, харилцаа хандлагадаа анхаарч ажиллах талаар албан хаагчдад тогтмол анхааруулж, чиглэл өгч ажилладаг. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнтэй холбоотой тогтоол, шийдвэр зэргийг албан хаагчдад танилцуулж, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд тогтмол түгээдэг. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах 1 удаагийн сургалтад хамрагдсан.
ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягтад зөрчил бүртгэгдээгүй. - Шинээр томилогдсон төрийн үйлчилгээний-1 албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” холбогдох бичиг баримтуудыг танилцуулж чиглүүлэх ажлыг авч хэрэгжүүлсэн. - Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулж, харилцаа хандлагыг үнэлэх үүднээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудаас байгууллагын цахим хуудсаар дамжуулан авч, үнэлгээг нэгтгэн дүгнэх ажлыг хэрэгжүүлсэн. 2025 онд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагуудаас авсан судалгааны дүнг нэгтгэн дүгнэхэд: ➢ Шалгалтад хамрагдсан нийт байгууллагын 95.9 хувь нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн тусалж чадсан, 4.1 хувь нь чадаагүй; ➢ Хяналт шалгалт, дотоод аудит хийсэн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг 57.5 нь хувь маш сайн, 40.8 хувь сайн, 1.7 хувь хангалтгүй; ➢ Хяналт шалгалт, дотоод аудит хийсэн албан хаагчийн мэргэжлийн ур чадварыг 55 хувь нь маш сайн, 43.3 хувь нь сайн, 1.7 хувь нь хангалтгүй; ➢ Хяналт шалгалт, дотоод аудит хийсэн албан хаагч асуудлыг түргэн шуурхай шийдэх өгөх тал дээр 46.6 хувь нь маш сайн, 49.2 хувь нь сайн, 4.2 хувь нь хангалтгүй зэргээр тус тус үнэлгээ өгсөн байна. Дээрх үнэлгээний дүнг үндэслэн албан хаагчдын ёс зүй, хяналт шалгалт, дотоод аудитын ажлын чанар, хүртээмжтэй байдлыг улам сайжруулах, мэргэжлийн ур чадварыг бүрэн хангалттай хэмжээнд нийцүүлэх талаар сургалт, арга хэмжээг дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнтэй холбоотой тогтоол, шийдвэр зэргийг албан хаагчдад танилцуулж, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд тогтмол түгээдэг.

- Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэгт гаргаагүй. - Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул ёс зүй, зөрчлийн хариуцлагын талаар бүртгэх мэдээлэл байхгүй.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтын ёс зүйн манлайлал
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул ёс зүйн дэд хороо зөрчилтэй холбоотой дүгнэлт гаргаагүй. - Төрийн хэмнэлтийн тухай 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтыг үндэслэн Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгоогүй. - Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул зөрчил, зөрчлийн шийдвэрлэлттэй холбоотой цахим хуудсанд байршуулах мэдээлэл байхгүй.
2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
- Албаны даргын 2025.11.25-ны өдрийн А/15 тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Үүний дагуу дэд хорооны бүрэлдэхүүний хөдөлгөөнийг системд бүртгэсэн. - Төрийн албан хаагчаас гомдол ирээгүй . - Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул мэдээллийн цахим санд бүртгэх мэдээлэл байхгүй.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын судалгаагаар албан хаагчдын харилцаа хандлагыг 98,3 хувь нь сайн үнэлгээ өгсөн байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнтэй холбоотой тогтоол, шийдвэр, хөтөлбөрийн хэрэгжилтийн хангаж ажиллахад бэрхшээлтэй асуудал байхгүй.
Санал:	
Саналгүй.	

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ДАРГА Л.ДАГИЙСҮРЭН

Ёс зүйн дэд хорооны дарга

ДОТООД АУДИТОР А.САНДАГДОРЖ

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Ц.БАТХУЯГ

2025 оны 12 сарын 30 өдөр

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

НЭГ. Товч танилцуулга:
Байгууллагын ажилтан албан хаагчдын төрийн албан хаагчийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд жил бүр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/12 дугаар тушаалаар баталгаажуулан 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” төвийн бүсийн зөвлөгөөн Дархан-Уул аймагт 2025 оны 04 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад нарийн бичгийн дарга Г.Нинжин хамрагдсан. Тус сургалтаар гомдол, мэдээлэл ирсэн үед хэрхэн бүртгэх, хуваарилах хэлэлцэх, шийдвэрлэх зэрэг мэдлэг мэдээлэл олгосон байна. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүн, нарийн бичгийн дарга нар суралцаж төгссөн мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал ба шийдвэрлэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бүсчилсэн хурлыг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ёс зүйн хорооны гишүүн Б.Энхманлай оролцсон байна. Мерит төсөл Төрийн албан хаагчийн хөгжлийн клуб хамтран Ёс зүйн манлайлал сэдэвт цахим уулзалтад ёс зүйн хорооны нарийн бичгийн дарга оролцож мэдээ, тайлан гаргах чиглэлийн аваад байна. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг мэдээлэл хүргэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 23-нд албан хаагчдад Ёс зүйн тухай хуулийн танилцуулгын талаар мэдээлэл бэлтгэж байршуулсан. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос байгууллагын ажилтан албан хаагчдын уур амьсгалыг эерэг болгох зорилгоор “Ёс зүйтэй хүн гэж мэндэлдэг хүнийг хэлнэ” хэмээх арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 30-нд зохион байгууллаа. 2025 оны 11 дүгээр сарын 01-30-ны хооронд Улсын хэмжээнд “Хүндэлье”-тусалж дэмжих, өгөөмөр сэтгэлээр хүндэтгэх, “Энэрье” - Энэрэн хайрлах, өршөөх, ууч сэтгэлээр хандах, хүндлэл-хил хязгаарын шугам энэрэл-сэтгэл зүрх гэсэн уриатайгаар хамт олноо хүндэтгэх, эелдэг найрсаг харилцааг бий болгох, дэмжих, урамшуулах соёлыг ажил хамтын орчиндоо төлөвшүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн ажиллахаар “Хөгжөөнт тэмцээн” тоглоом мөн Талархалын захидлыг албан хаагч бүрээр бичүүлсэн байна. Байгууллагын ёс зүйн хорооноос нээлттэй цахимаар мэдээлэл олгох зорилгоор байгууллагын цахим вэб сайт, пэйж хуудас, самбарт байршуулах ажлыг тогтмол хийж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Байгууллагын ёс зүйн дэд хорооноос албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг мэдээлэл хүргэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Дархан-Уул аймгийн насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Ажлын байран дахь эерэг харилцаа, хандлага” сэдвээр албан хаагчдад сургалт зохион байгууллаа.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга Б.Энхболд нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газарт 2025 оны 05 дугаар сарын 01-ээс шилжин ажиллах болсон. Иймд Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.8 дах хэсэгт заасны

дагуу Захиргаа удирдлагын хэлтсээс албан хаагчдаас дэд хорооны гишүүн сонгох ажлыг зохион байгуулсан. Тус дэд хорооны гишүүнээр Хяналтын хэлтсийн Улсын байцаагч Б.Хишигсүрэн сонгогдсон байна. Гэвч эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авсан тул Ёс зүйн дэд хорооны хурал зохион байгуулах боломжгүй байсан болно. Улсын байцаагч Б.Хишигсүрэн нь 2025 оны 08 дугаар сарын 20-оос Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжин ажилласан тул Захиргаа удирдлагын хэлтсээс дэд хорооны гишүүнийг сонгох ажлыг 2025 оны 10 дугаар сард хамт олны дунд цаасаар санал хураалтаар гишүүн нөхөн томилсон байна.
2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2025 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталгаажуулан 3 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2025 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн А/28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар ажиллах журмаа баталгаажуулсан.	✓ Албан хаагчийн дунд нийтэд хамааралтай төлбөртэй сургалтууд, санхүүгийн асуудал үүсэж хэмнэлтийн хуулиар хойшлогдсон болно. ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг тооцох үнэлгээ хийх санхүүжилтгүй болно. ✓ Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшууллын санхүүжилт байхгүй болно.

Санал:
Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс ёс зүйн дэд хороодыг чадавхижуулах Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй сэдэв сургалтыг 2026 онд зохион байгуллахаар төлөвлөсөн байна. Цаашид төрийн байгууллагуудад ёс зүйн сургагч багш нараар мэдээлэл болон эрсдлийн үнэлгээ хийлгэх талаар дэмжлэг үзүүлж хамтран ажиллана уу.

Баталгаажуулалт:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга		(Т.Ганболд)
(Албан тушаал)	(гарын үсэг)	(гарын үсгийн тайлал)
Ёс зүйн дэд хорооны дарга		(Г.Нинжин)
(Албан тушаал)	(гарын үсэг)	(гарын үсгийн тайлал)
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга		(С.Баасан)
(Албан тушаал)	(гарын үсэг)	(гарын үсгийн тайлал)

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хороо нь 2025 онд 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.Үүнд: 1. Дорж овогтой Наранцэцэг. Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга, Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хорооны дарга, Хүнс судлалын ухааны магистр Төрийн албанд 25 жил, үүнээс Эрүүл мэндийн газарт 3 жил ажиллаж байна 2. Очир овогтой Хишигсүрэн. Эрүүл мэндийн газрын ЭМТҮХ-ийн Сувилахуй болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хорооны гишүүн, Боловсрол судлалын Магистр, МУ-ын Зөвлөх зэрэгтэй сувилагч.Төрийн албанд болон эрүүл мэндийн салбарт 30 жил ажиллаж байна. 3. Батзориг овогтой Одонтунгалаг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн Тархвар судлаач, Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга.Төрийн албанд болон Эрүүл мэндийн газарт 7 жил ажиллаж байна. 4. Ганболд овогтой Эрдэм.Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн,Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хорооны гишүүн.Төрийн албанд 3 жил, эрүүл мэндийн салбарт 8 жил ажиллаж байна. 5. Баянжаргал овогтой Тэмүүжин. ЭМГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, ёс зүйн дэд хорооны гишүүн.Төрийн албанд 5 жил, үүнээс Эрүүл мэндийн газарт 3 жил ажиллаж байна.
Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хорооны 2025 оны 9 заалттай үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсанаас төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хүрээнд 6 ажил, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд удирдах албан тушаалтнуудыг хамруулан оролцоог хангаж, гомдол, мэдээлэл, зөрчил шийдвэрлэлт, тайлан мэдээ, цахим системтэй холбоотой 3 ажил тус тус төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн байна. Үүнд: 1.Эрүүл мэндийн хөгжлийн төв, Амьдралд суурилж суралцахуй ТББ-тай хамтран “Мэргэжлийн ёс зүй, харилцааны ур чадвар, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023” стандартын сургалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2025 оны 05 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын 221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан, албан хаагч хамрагдав. 2.“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага, нөлөөлж буй хүчин зүйл манлайлал, байгууллага хамт олны соёл” сэдэвт хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хороо, ёс зүйн хэсгийн хороо, ёс зүйн багийн гишүүд хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн газрын 20 эмнэлгийн ажилтан, албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. 3."Илтгэх индрийн ирээдүй" ТББ, Юнител компанийн Дархан-Уул аймаг дахь салбартай хамтран “Үр дүнтэй төлөвлөлт” сургалтыг эрүүл мэндийн салбарын удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн 94 хүнийг хамруулан зохион байгуулж, Илтгэх индрийн ирээдүй ТББ-ын үүсгэн байгуулагч, үндэсний сургагч багш Д.Хүрэлбаатар хувь хүний төлөвлөлт, ажил амьдралын хувийн зохион байгуулалт, ажил, амьдралаа хэрхэн үр дүнтэй зөв төлөвлөх талаар илтгэл тавьж, хүн бүр хүүхдүүдэд уншсан номоо хандивлах аяныг

өрнүүлж, нийгэмд эерэг уур амьсгалыг түгээхэд эрүүл мэндийн салбарын ажилтнууд хувь нэмрээ оруулсан.

4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг таниулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн газрын хурлын танхимд **“Ёс зүйн мод”**-ыг байршуулж, ёс зүйн модоо албан хаагч, ажилтан бүр өөрийн эрхэмлэдэг ёс зүйн зарчмаар чимэглэж, эрхэмлэдэг, ажилдаа хэрэгжүүлдэг ёс зүйн зарчмаа хамт олондоо таниулж сурталчиллаа.

5.Эрүүл мэндийн газрын 2 болон 3 дугаар давхарт “Алтан цаг”-ийг байршуулсанаар төрийн албан хаагч нь ажлын цагаа бусдаар шаардуулахгүйгээр баримтлах, цагийн нягтралтай, үр бүтээлтэй ажиллах шаардлагатай байгааг тэмдэгт, дүрслэлийн аргаар албан хаагчиддаа ажлын бүтээмжтэй байхад уриалга дэвшүүлж, хэвшил болгох ажлыг санаачлан төрийн албан хаагчидтайгаа хамтран ажиллаж байна.

6.Хамт олны эерэг, хамтач уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх санаачлагын хүрээнд “Өнгөлөг уулзъя” бага үдийн цайны өдөрлөгийг зохион байгуулсан.Нийт 61 ажилтан, албан хаагчдыг 6 өнгийн багт хуваарилж, баг бүр заасан өнгөний дагуу бага үдийн цайнд хамт олноо дайлах өнгийн бүтээгдэхүүнийг баг бүр сэтгэл гарган бэлтгэн ирсэн байна.Уг өдөрлөгийн хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилж, Ёс зүйн дэд хорооноос санаачлан хэрэгжүүлсэн ажлуудаа тайлагналаа.

7.Төрийн албан хаагчийн хөгжлийн клубээс зохион байгуулсан “Эртэч манлайлагч-өглөөний цай”-ны арга хэмжээнд тус газрын ёс зүйн дэд хорооны 2 гишүүн цахимаар оролцож, холбогдох мэдээллийг авч хэрэгжүүлж ажиллаж байна.

8. Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”, тус хорооны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг”-ийн талаар тус газрын албан хаагчдад танилцуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудсаар нийт 41 албан хаагчийг үнэлэн мэдээллийг цуглуулсан. Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/148 дугаар тушаалаар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцож үнэлэх 5 албан тушаалтны бүрэлдэхүүнтэй үнэлгээний багийг томилон эрсдэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийсэн. Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудсанд тусгасан 9 чиглэлийн 33 асуумжаар магадлал болон нөлөөллийн түвшинг /1-5 оноо/-оор төрийн албан хаагч болон байгууллагын эрсдэлийг үнэлүүлсэн.Байгууллагын хүрээнд эрсдэлийн тохиолдох магадлал давтамж 1.9 оноо буюу /**тохиолдох магадлал бага**/ /P/, эрсдэлийн нөлөөлөл 1.9 оноо буюу **нөлөө бага** /хохирол бага, бодит нөлөө нь бага илрэх/ /C/-тай гарсан байна.Эрсдлийн түвшинг тодорхойлоход R=1.9*1.9=**3.61** байгууллагын эрсдлийн түвшин IV түвшинд буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба шууд арга хэмжээ шаардлагагүй, хяналтыг үргэлжлүүлэхээр чиглэл гарч байна.Албан хаагчдын эрсдэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийхэд эрсдэлийн I, II түвшин буюу маш өндөр, өндөр эрсдэлтэй албан хаагч үнэлэгдээгүй тул ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах шаардлагатай албан хаагч байхгүй байна.

III түвшинд буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 7 албан хаагч, IV түвшинд буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн 34 албан хаагч байна.Төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдэлд өртөх эрсдэлийн үнэлгээ, болон Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-д заасан бусад тайланд үндэслэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажлуудыг 2026 онд төлөвлөн хэрэгжүүлэхээр ажиллана.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Тус газрын дарга, хэлтсийн дарга нарын манлайллыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

1.Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Их хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүйн дэгийн байнгын хороо, Монгол Улсын Ёс зүйн хороо, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлүүд хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” төвийн бүсийн зөвлөгөөн 2025

оны 04 дүгээр сарын 14,15-ны өдөр зохион байгуулагдаж, Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга удирдах албан тушаалтан 5, нийт 6 удирдах албан тушаалтан, ёс зүйн дэд хорооны 4 гишүүн, төрийн албан хаагч 5, нийт 11 хүн хамрагдсан. 2.Европын холбооны хамтарсан санхүүжилттэй Найрамдал төслөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчдыг чадавхижуулах сургалт модуль 5 “Хамтын сэтгэлгээ” сэдэвт 48 цагийн богино хугацааны эрчимжүүлсэн сургалтад Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн 2 дарга нийт 3 удирдах албан тушаалтан хамрагдаж гэрчилгээ авсан. 3.Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, нэгдсэн эмнэлгийн дарга, тасгийн эрхлэгч, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн нийт 40 хүнийг хамруулан “Сэтгэлгээний арга хэрэгсэл” сэдэвт сургалтыг ёс зүйн дэд хорооноос 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан.Сургалтыг Оюуны чадварын IQ төвийн Дархан-Сэлэнгэ хариуцсан координатор, 22-р сургуулийн захирал Д.Түмэн-Өлзий зааж, сургалтаар эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудад сэтгэлгээний өөрчлөлтийн талаар мэдлэг хандлагыг төлөвшүүлэх, эерэг харилцаа хандлагыг бий болгоход чухал ач холбогдолтой сургалт болсон. 4.Тус газрын ёс зүйн дэд хороонд 2025 оны тайлант хугацаанд төрийн албан хаагчтай холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гараагүй.Иймд байгууллагын цахим хуудсанд байршуулах шаардлагагүй, гомдол мэдээлэл ирээгүй талаарх тайланг Дархан-Уул аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд цахим хэлбэрээр хүргүүлсэн. 5.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах зардлыг 2025 оны төсөвт тусгах саналыг ёс зүйн дэд хорооны зүгээс Эрүүл мэндийн газрын удирдалга төлөвлөлт санхүүгийн хэлтэст гаргаж өгсөн ба Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 1.5, 3.8-д заасан ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг 2025 оны байдлаар шийдвэрлээгүй байна.Үйл ажиллагааны холбогдох зардлыг гишүүд хувиасаа гаргах, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нөөц бололцоондоо тулгуурлан шийдвэрлэх замаар үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллалаа.Цаашид 2026 оны төсөвт дээрх зардлыг тусгаж, дэмжиж ажиллах талаар Эрүүл мэндийн газрын дарга Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн даргад хамт олны хурлаас үүрэг чиглэл өгсөн болно.
2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
1.Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 05 сарын 08-ны өдрийн А/67 тоот тушаалаар Эрүүл мэндийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон ба 2025 оны 9 дүгээр сард 1 гишүүн өөрийн санаачлагаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул хамт олны хурал зохион байгуулж, хамт олны олонхийн саналаар улсын байцаагч Б.Тэмүүжин ёс зүйн дэд хорооны гишүүнээр нөхөн сонгогдсон. Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх ёс зүйн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалтад заасны дагуу ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд 2025 онд орсон өөрчлөлтийг цахим системд бүртгэсэн. 2.Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл 2025 онд тус дэд хороонд ирээгүй тул дүгнэлт гараагүй. 3.Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт, тайланг хуульд заасан хугацаанд мэдээллийн цахим санд байршуулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 4 удаагийн сургалт, 3 удаагийн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, байгууллагын албан хаагчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлсэнээр албан хаагчдаас ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол санал ирээгүй.	1.2025 оны ёс зүйн дэд хорооны тайланг Монгол улсын Ёс зүйн хорооны 2025.12.01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын дагуу авах талаар 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдөр цахим арга хэмжээний үеэр танилцуулж, тус шалгуурын дагуу тайлан гаргахад хүндрэлтэй байсан. 2.Байгууллагын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд зарцуулах төсөв санхүүгийн эх

2.Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал” батлагдсанаар байгууллагын эрсдэлийн үнэлгээний суурь түвшинг тодорхойлох нөхцөл бүрдсэн.	үүсвэргүй тул ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулахад бэрхшээл алхам тутамд тулгамдаж байна. 3.Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн ажлын ачаалал их, гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд үндсэн ажил хаягдах ачаалал улам ихсэх нөхцөл бий болж байгаа нь энэ 2 жилийн хугацаанд харагдаж байна.
Санал:	
1.Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 1.4, 1.5, 3.7, 3.8 дахь заалтууд бүрэн хэрэгжихгүй байгаа тул Сангийн яам болон төсвийн эрх мэдэл бүхий төрийн байгууллага, төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушалтнуудад энэ чиглэлээр **албан бичгээр** үүрэгжүүлэх, төсөвт тусгахад дэмжлэг үзүүлэх. 2.Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтыг тогтмол зохион байгуулах, ялангуяа гомдол мэдээллийг ёс зүйн зөрчил мөн эсэхийг бусад зөрчлөөс хэрхэн ялгаж хүлээн авах, хэрхэн шийдвэрлэх арга зам, тайлагнах асуудлын талаар сургалт авах саналтай байна.	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Эрүүл мэндийн газрын дарга: Б.Эрдэнэтулга

Ёс зүйн дэд хорооны дарга
Хяналт шалгалтын хэлтсийн дарга: Д.Наранцэцэг

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Тархвар судлаач: Б.Одонтунгалаг

2025 оны 12 сарын 30-ны өдөр

Received
Copyright Office
Library of Congress
JUL 29 1940

Ёс зүйн хорооы 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Дархан-Уул аймгийн Худалдан авах ажиллагааны газрын ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үндэсний хөтөлбөртэй уялдуулан тайлант хугацаанд доорх ажлыг зохион байгуулж ажилласан. Ёс зүйн дэд хороонд ёс зүйн зөрчлийн талаар гомдол ирээгүй болно.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Ёс зүйн сургалтын тухай: Газрын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зорилтыг танилцуулах сургалтыг 1 удаа, Газрын удирдлага болон ёс зүйн дэд хорооны гишүүд, албан хаагчдад ёс зүйн дэд хорооны чиг үүргийг журмын дагуу танилцуулах сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэмжээ, зарчим, шаардлагыг ажлын байран дээр танилцуулах хуудсыг байршуулж албан хаагчдад танилцуулсан. **Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлын тухай:** Төрийн албан хаагчид ёс зүйн зөрчлөөс сэргийлж 8 албан хаагчид 25 ширхэг гарын авлагыг тарааж өгсөн. Ёс зүйтэй төрийн албан хаагч гэж хэн бэ? сэдвээр Ёс зүйн зөрчлийн тухай бодит жишээн дээр ажиллаж өөрсдийн санал бодлоо хуваалцан хэлэлцүүлэг зохион байгуулав. 12 дугаар сарын эхний долоо хоногийг Талархлын 7 хоног болгон зохион байгуулж албан хаагч бүрт урмын үг болон витаминжуулалтыг зохион байгуулсан. **Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ**: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээг маягтын дагуу хувь хүний нууцыг хамгаалах хуулийн хүрээнд албан хаагч бүрээс судалгаа авсан болно.Тус үнэлгээгээр 100 хувь нь ёс зүйн зөрчилд өртөх эрсдэл бага гарсан болно.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Тайлант хугацаанд ёс зүйн дэд хороонд гомдол зөрчил гараагүй учир дэд хорооноос дүгнэлт гараагүй болно. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг цахим системд оруулж байгаа болно.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Ёс зүйн дэд хорооны гишүүдийг Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт цахим системд https://hrm.csc.gov.mn/ethics/violationcomplain бүртгэсэн болно. Ёс зүйн дэд хороонд ёс зүйн зөрчлийн талаар гомдол ирээгүй болно.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл

Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй.	-
Санал:	
Цаашид ёс зүйн сургалтыг тогтмол зохион байгуулах, хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтийг албан хаагчдад шуурхай танилцуулах, ёс зүйн соёлыг байгууллагын түвшинд цаашид бэхжүүлэх нь зүйтэй.	

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- Үндэсний хөтөлбөрий хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Газрын дарга _____ (Б.Баасанжаргал)
/албан тушаал/ */гарын үсэг/* */гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга

Ахлах мэргэжилтэн _____ (Б.Батчимэг)
/албан тушаал/ */гарын үсэг/* */гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг

ХААХ мэргэжилтэн _____ (Б.Наранбилэг)
/албан тушаал/ */гарын үсэг/* */гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 12 сарын 30-ны өдөр

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
"ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

НЭГ. Товч танилцуулга[1]

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны "Ёс зүйн дэд хороо"-г албаны даргын 2024 оны 02 дугаар сарын 12-ны А/03 тушаалаар байгуулсан.

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд

Дарга Г.Гэрэлтуяа /Ахлах мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга Д.Ганбаяр /Мэргэжилтэн/
Гишүүн Ш.Эрдэнэзул /Мэргэжилтэн/

Ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасны дагуу шалган шийдвэрлэж, ажлын тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргэж ажиллах үүрэг хүлээсэн.

Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчил, гомдол мэдээлэл гараагүй болно.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

- Албаны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн "Системийн сэтгэлгээ" сургалт /2025.01.30-31/, ТАЗ-өөс зохион байгуулсан "Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах" сургалт, Албан хаагчийн тоо 5 /2025.02.07/
- Европын холбооны Найрамдал төсөл, Дархан-Уул аймгийн ТАЗ-тэй хамтран зохион байгуулсан 10 модуль Сэтгэлгээний хөгжил, өсөлттэй сэтгэлгээ сургалт, ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяа, мэргэжилтэн З.Одмаа, Ш.Эрдэнэзул, Д.Ганбаяр
- Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт-ТЗУХ, Дарга Б.Оргил, ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяа
- "СиТиЭс" ХХК, Сангийн яам болон Мэргэшсэн Нягтлан бодогчдын институттэй хамтран зохион байгуулсан санхүүгийн программд хийсэн шинэчлэлт сайжруулалтын талаарх сургалт, Нягтлан бодогч Д.Энхтунгалаг
- Аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан Төрийн өмчийн мэдээллийг нэгтгэн, цахим системд бүрэн шилжүүлэх" сургалт, мэргэжилтэн Ш.Эрдэнэзул /2025.10.09/
- Аймгийн ХШҮХ-ээс зохион байгуулсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах нь" сэдэвт танхимын сургалт, ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяа /2025.10.10/
- Канад-Монголын Мерит төсөл, төслийн зөвлөх Фрэнк Поттер аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Салбар зөвлөлтэй хамтран "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт орон нутгийн бодлого боловсруулагчдад зориулсан сургалт, ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяа /2025.11.24-11.25/
- Төрийн байгууллагуудын Ёс зүйн дэд хорооны "Төрийн албан хаагчийн ёс зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал ба шийдвэрлэх арга зам" сэдэвт эрдэм шинжилгээний сургалт, ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяа, мэргэжилтэн Ш.Эрдэнэзул /2025.12.05/-д тус тус хамрагдсан.

Үр дүн: Хамрагдсан албан хаагчийн тоо 6

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал:

- ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гарган аймгийн ХЭЗХ-ийн мэргэжилтэн Э.Хонгорзулд хянуулан баталгаажуулж цахимаар АТГ-т илгээсэн.
- Албаны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж нийт 8 зорилт 24 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Гүйцэтгэл 100%
- ЗАА-ны вэб сайт болох https://governor.da.gov.mn, аймгийн "Дархан хот", албаны "Захирагчийн ажлын алба Дархан-Уул" facebook-т үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт байршуулан иргэдэд ил тод хүртээмжтэй мэдээлж ажилласан.
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын "Шил ажиллагаа" https://shilen.gov.mn/home сайтад албаны 2025 оны 1-4 дүгээр улирлын тайлан, мэдээллийг шинэчлэн оруулж баталгаажуулан 84-100%-иар дүгнэгдсэн.
- Албаны 7 хоног, сар, улирал, ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, аймгийн Засаг дарга, хуралдаан, шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь гарган аймгийн ТЗУХ-т хүргүүлсэн.
- Албаны албан хаагчдын хариуцсан ажилдаа тусган ажиллах хуулийн жагсаалтыг гарган, албаны мэдээллийн самбарт байршуулан төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэж ажилласан.

---

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаанытайлагнана.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Албаны Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 7 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.   

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
- Байгууллагын албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахин ажилласан. - Ye шаттай сургалтад хамрагдсанаар ёс зүйн зөрчил гараагүй.	- Ёс зүйн дэд хорооны албан хаагчидад олгох мөнгө урамшуулалын төсөв байгууллагын төсөвт батлагдаагүй. - Үйл ажиллагааны зардал төсөвт тусгагдаагүй.

Санал:
Хуульд заасан үйл ажиллагааны зардал, урамшууллыг төсөвт тусгах

Шалгах хэсэг:

- "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ЗАА-НЫ ДАРГА Б.ОРГИЛ

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга Г.ГЭРЭЛТУЯА

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.ГАНБАЯР

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 12 сарын 25-ны өдөр

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Нэгдсэн эмнэлгийн Ёс зүйн дэд хорооны гишүүн сонгох нийт ажилтны санал асуулгыг 2025.02.05-02.06 өдөр 2 үе шаттай явуулсны үндсэн дээр 2025 оны 02 сарын 12-ны өдрийн Нэгдсэн эмнэлгийн даргын А/10 тоот тушаалаар Дэд хорооны дарга: Д.Өлзийбаяр, нарийн бичгийн дарга: Э.Ариунзул, гишүүд: Х.Оюунбилэг, Д.Шүрхүү, Т.Хулан гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороо байгуулагдсан.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

1. 2025 оны Дархан нэгдсэн эмнэлгийн ёс зүйн дэд хорооны үйл, ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажилласан.

- Төлөвлөгөөнд “Төрийн албаны ёс зүйн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлж, шударга, ёс зүйтэй байх үзэл, хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлснээр ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах” чиглэлээр 15 ажил, “Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх судалгаа, дүн шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулах чиглэлээр” 3 ажил, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх” чиглэлээр 2 ажил, “Нэмэлт хийгдэх үйл ажиллагаа”-ны чиглэлээр 3 ажил, нийт 4 үндсэн чиглэлийн 23 ажил төлөвлөсөн байна.

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА Д.ӨЛЗИЙБАЯР
БАЙГУУЛЛАГЫН ТАМГА, ТЭМДЭГ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дархан-Уул 2025.02.20

№	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Зарцуулах төсөв	Хугацаа /улиралаар/ 1	2	3	4	Хариуцах ёс зүйн дэд хорооны гишүүн
1. Төрийн албаны ёс зүйн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлж, шударга, ёс зүйтэй байх үзэл, хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн сургалтын үйл ажиллагаар хэрэгжүүлснээр ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг бууруулах										
1	Төрийн албаны ёс зүйн дэд хорооны цахим хуудастай болох	-	-	100%		+				Д.Өлзийбаяр Э.Ариунзул
2	Нэгдсэн эмнэлгийн асрагч нарын бариимжа олгох сургалтад Төрийн албаны ёс зүйн тухай орулах	-	-	100%		+				Д.Өлзийбаяр Э.Ариунзул
3	Төрийн албаны ёс зүйн дэд хорооны “Сургалтын хөтөлбөр” боловсруулан, батлах, хэрэгжүүлэх	-	-	100%		+				Д.Өлзийбаяр Э.Ариунзул
4	Полиглиник-1, поликлиник-2, НЭМ, ЭМДэмжих тев, цусны сангбар тев, уламжлалтын тасгийн нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-	+				Д.Шүрхүү, Б.Амаржаргал
5	хүлээн авах ахлалтай тусламж, ахлалтай түргэн тусламж /103/, дүрс оношлогоо, эмэгт судалаын нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-	+				Д.Өлзийбаяр, Х.Оюунбилэг
6	Шинэ ажилтны сургалт /3 сарын/	Хамрагдсан ажилтны тоо	-	95%	-	+				Э.Ариунзул
7	Сэтгэц сурьель, ариутгал, мэдрэл, сэргээн засах тасаг, уйлчилгээний албаны нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-	+				Д.Шүрхүү, Х.Оюунбилэг
8	Гэмтэл, МЭЗ, мэс засал, хагалгаа, хөнгөвчлөх тасаг, байгууллагын менежмент, эм зүйн албаны нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-	+				Д.Өлзийбаяр, Б.Амаржаргал
9	Шинэ ажилтны сургалт /4-6 сарын/	Хамрагдсан ажилтны тоо	-	95%	-	+				Э.Ариунзул
10	Хүүхэд, хөлдөлт, дотрын тасгийн нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-		+			Д.Шүрхүү, Б.Амаржаргал
11	Аюулгүй, нөхөн, эмнэлгийн лабораторийн тасгийн нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-		+			Д.Өлзийбаяр, Х.Оюунбилэг
12	Шинэ ажилтны сургалт /7-9 сарын/	Хамрагдсан ажилтны тоо	-	95%	-		+			Э.Ариунзул
13	Эрүүл зөрлөг төлөвлөлтийн алба, мэдээлэл технологийн алба, ХНСХА албаны нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-			+		Д.Шүрхүү, Х.Оюунбилэг
14	Санхүү бүртгэлийн алба, суміпакуйн алба, ХСХА, ЭМТАЧАБА эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны нийт албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан ажилтны тоо	-	90%	-			+		Д.Өлзийбаяр, Б.Амаржаргал
15	Шинэ ажилтны сургалт /10-12 сарын/	Хамрагдсан ажилтны тоо	-	95%	-				+	Э.Ариунзул
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх судалгаа, дүн шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулах										
1	Төрийн албан дахь ёс зүйн асуудлаа ба зөрчлөө өртөх нөлөөллийн хүчин зүйлс, эрсдэлийн талаар нийт ажилчдын санаа бодлыг тандан, төлөв байдлыг тодорхойлох судалгаа авах	Судалгааны тоо	-	85%	-				+	Нийт гишүүд
2	Төрийн албан хаагчийн ёс зүй, шударга байдлын төлөвшилд өөрийн болон хамт олон, удирдлагын үнэлгээ хийж, үр дүнд суурилсан сургалтын үйл ажиллагаа төлөвлөх	Судалгааны тоо	-	85%	-		+	+		Нийт гишүүд
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай холбоотой хөнгөвчлөх тэмдэн урагдаан, эсүүл авч, хэлэлцүүлэг зохион байгуулах	Оролцогчий н тоо	-	100%				+		Нийт гишүүд
3.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх										
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар ирүүлсэн гаргасан гомдол, мэдээлэл хүлээн авсан тухай бүрт хуралдаж, дүн шинжилгээ хийж, удирдлагад хүргүүлэн, шийдвэрийг ХНҮМТ программд оруулах	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тоо	-	100%	-	+	+	+	+	Нийт гишүүд
2	Ёс зүйн зөрчил илэрч шийдвэрлэгч үйл ажиллагааны мэдээ, тайлбар олон нийтэд тогтмол мэдээлэх, ил тод байдлыг хангах	Мэдээлсэн тоо	-	100%	-					Д.Өлзийбаяр Э.Ариунзул
4. Нэмэлт хийгдэх үйл ажиллагаа										
1	Төрийн албаны эмэлэл болон дэмэд шатны байгууллага, удирдлагаас ирүүлсэн албан бичиг, судалгаа, тайлан, мэдээг хугацаанд хүргүүлэх	Хүргүүлсэн тоо	-	100%	-	+	+	+	+	Д.Өлзийбаяр Э.Ариунзул
2	Төрийн албаны эмэлэл болон дэмэд шатны байгууллагаас зарлагдсан сургалт бүсэд үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдах	Оролцсон үйл ажиллагаан ы тоо	-	90%	-	+	+	+	+	Нийт гишүүд
3	Төрийн албаны ёс зүй, ихлбогдох хууль тогтоомжийн талаарх сургалтад ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулах	Хамрагдсан сургалтын тоо	-	90%	-		+		+	Д.Өлзийбаяр, Э.Ариунзул

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /Э.АРИУНЗУЛ/

2. Ёс зүйн дэд хороо нь шинэ ажилтны сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж 2 удаагийн сургалтаар 55 ажилтан хамруулсан.

БАТЛАВ

ЕС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА Д.ӨЛЗИЙБАЯР
БАЙГУУЛЛАГЫН ТАМГА, ТЭМДЭГ

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ЕС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ШИНЭ АЖИЛТНЫ 6 ЦАГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Зорилго:

1. Төрийн албаны ес зүйн үндсэн зарчмуудыг эзэмшүүлэх
2. Эрүүл мэндийн салбарт хамаарах ес зүйн онцлогийг ойлгуулах
3. Шинэ ажилтнуудад хууль, журам, дотоод дүрмийг танилцах

Дархан –Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн "ШИНЭ АЖИЛТАН"-д төрийн албаны ес зүйн тухай хууль танилцах, суртчилах

Хамрах хүрээ:

- Шинээр ажилд орж байгаа нийт албан хаагч нар

Хүлээгдэх бүй ур дүн:

- Төрийн албан хаагчийн ес зүйн тухай мэдлэг олгох
- Зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг сайжруулах

Хугацаа: 2 едер

№	Үйл ажиллагаа	Чиглэл	Хуваарь
1	Байгууллагын танилцуулга. Төрийн албаны ес зүйн сууль	Эмнэлгийн түүх, зорилго, үнэт зүйлс	1-р едер
		Хөдөлмөрийн горим, цагийн, номгүдэл цагийн, албан тушаалын тодорхойлолт	
		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай Үндэсн зарчим, шүдэрга ёс, ил тод байдал, хариуцлага	
		Эрүүл мэндийн салбарын ес зүй /илтгэл/	
		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	
		Хүнд эмгэлтэй харилцааны арга, техник	
		Даалгавар: "Ес зүйн зөрчлийн жишээ кейс" шийдэрлэх	
2	Хамтын ажиллагаа	Хамт олны харилцаа	2-р едер
		Туршлагатай ажилтныг асвсн ёс зүйн дэд хорооны гишүүний менторооор томилох	
		"Асуун цахим чат групп үүсгэх	
		Даалгавар: "Багийн гишүүнтэй хосоор ажиллах" кэпэлцүүлэг, асуулт-хариулт	

2025.04.29ны мягмар гарит 14:00 цагт В1танхимд
шинэ ажилтны сургалтад хамрагдах эм зүй, сувилагч тусгай мэргэжилтэн

№	Овог	Нэр	Тасаг, нэгж	Албан тушаал	Гарын үсэг
1	Эрдэнэчулуун	Хос-Үенгэ	итт	эмч	
2	Мөнхбат	Булганаагва	поли-1	нэгэн зүйч	
3	Баттуяа	Баттуяа	хөнгөвчлөх	сувилагч	
4	Ганзориг	Сувд-Эрдэнэ	амаржих	эх баригч	
5	Нямжав	Арнуужаргал	үйл.алба	асрагч	
6	Нандинцэцэг	Золзаяа	мэдрэл	сувилагч	
7	Цэдэнжамба	Оргилсайхан	итт	мэргэч	
8	Сонинбаярт	Бидэнд	итт	мэргэч	
9	Инжинооров	Анибаяр	сэнхүү	нярав	
10	Баяржаргалын	Бадамцэцэг	эм зүйч алба	эм найрлагч	
11	Энхсүх	Бямбацэцэг	мэдрэл	эмч	
12	Чимэддорж	Энхчимэг	хавсгаа	эрх зүйч	
13	Лхагвасүрэн	Болормаа	сурьеэ	сувилагч	
14	Дэваадорж	Нарандэлэг	сурьеэ	сувилагч	
15	Газарус	Нарангэрэл	Дотор	сувилагч	
16	Төрөөгөө	Өлзийсайхан	Мэдрэл	сувилагч	
17	Ганзориг	Одончимэг	маз	сувилагч	
18	Энхбат	Жаргалмаа	хавсгаа	сувилагч	
19	Дэвээсамбуу	Алтанцэцэг	гал тогоо	ахлах тогооч	
20	Адъяа	Цэндсүрэн	гал тогоо	үйлчлэгч	
21	Халзан	Уранбаяр	аршуулал	үзлэгч	
22	Цэдэнбал	Бадамцэрэн	амаржих	эх баригч	
23	Эрдэнэцэрэн	Тунгалаг	үйл.алба	Асрагч –поли2	
24	Цогзан	Мичээлэл	үйл алба	Асрагч-эмэгт суд	
25	Батбаяр	Үүрийнтуяа	гал тогоо	туслах ажилтан	
26	Баянтогс	Энх-Од	гал тогоо	туслах ажилтан	
27	Цэнд-Аюуш	Долгормаа	эх лаб	лаборант	
28	Батсайхан	Цэнгүүн	эх лаб	лаборант	
29	Ендон	Чимэдцэцэг	гал тогоо	тогооч	

25.08.15ны 13:00 цагт ШИНЭ АЖИЛТАНы сургалтад хамрагдах жагс

1	Сольхүү	Нандинцэцэг	нярав
2	Чойжилсүрэн	Мэндсайхан	сувилагч
3	Ринчинсэнгэ	Цэвээлмаа	эмч
4	Доржготов	Загдбазар	эмч
5	Бямбажав	Алтанхуяг	сувилагч
6	Ганболор	Баасандулам	сувилагч
7	Баатаржав	Цэрмаа	сувилагч
8	Цэдэнбал	Нарантуяа	сувилагч
9	Батжаргал	Баянжав	сувилагч
10	Бат-Олзий	Нямцэцэг	эмч
11	Баасанхүү	Арнуужаргал	үйлчлэгч
12	Болд	Алимаа	асрагч
13	Баярмөнх	Мөнхцэцэг	эх баригч
14	Дэваа	Нарангэрэл	лаборант
15	Уламбаяр	Золзаяа	эмч
16	Батхишиг	Мөнхзаяа	сувилагч
17	Болдбаатар	Уянга	буртгэл
18	Дамба	Сарангэрэл	сувилагч
19	Дэвээнням	Мичидмаа	эх баригч
20	Номаа	Түмэндэмбэрэл	сувилагч
21	Дэвээжав	Сэргэлэнцэцэг	сувилагч
22	Тербат	Лхагважав	асрагч
23	Баяржаргал	Баярмаа	асрагч
24	Бямбаа	Энхжаргал	асрагч
25	Бадрах	Уртнасан	үйлчлэгч
26	Батболд	Шинэсэран	эмч

3. Нэгдсэн эмнэлгийн нийт ажилчдад ёс зүйн сургалтыг дэд хорооноос батлагдсан хөтөлбөр, сэдвийн хүрээнд 2025 онд нийт 6 удаагийн танхимын сургалтаар 167 эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулж соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг хийсэн байна. /тасаг, нэгжийн удирдлагууд- 50, үйлчилгээний алба- 53, поликлиник-1 тасаг-18, сэргээн засах тасаг- 12, төвлөрсөн ариутгалын тасаг- 11, сэтгэцийн тасаг-9, сүрьеэгийн тасаг- 7, эзта- 7/

БАТЛАВ

ЕС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА Д.ӨЛЗИЙБАЯР
БАЙГУУЛЛАГЫН ТАМГА, ТЭМДЭГ

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ЕС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НИЙТ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Зорилго:

1. Төрийн албаны ес зүйн үндсэн зарчмуудыг эзэмшүүлэх
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх

Зорилт бүлэг:

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт их эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн ажилтнууд

Хамрах хүрээ:

Төрийн албаны ес зүйн сууль ойлгогч, хууль зөр зүй, нийтлэг зөрчлүүд, кейс судалгаа, урьдчилан сэргийлэх арга зам

Хугацаа:1 едер /1-2 цаг/

№	Үйл ажиллагаа	Чиглэл	Хуваарь
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн сууль ойлгогч	Ёс зүйн үндсэн ойлгогч	30 минут
		Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим	
		Эрүүл мэндийн салбар дахь ёс зүйн онцлог	
2	Ёс зүйн зөрчлийн нийтлэг хэлбэр, шалтгаан	Нийтлэг зөрчлүүд (авлига, харилцааны доголдол, мэдээллийн нууцлал алдагдуулах гэх мэт)	30 минут
		- Хүний эрх, үйлчлүүлэгчийн эрх хөнөх, судалгаа, жишээ	
3	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам	Харилцаа, хандлагын совл	30 минут
		Хувь хүний хариуцлага	
		Ёс зүйн дэд хорооны үүрэг	

Сургалтын хэрэгслүүд:

- PowerPoint танилцуулга
- Хэвлэмэл гарын авлага, ёс зүйн хууль, дүрэм
- Кейс судалгааны материал
- Видео сургалт (хүсвэл ашиглана)
- Санал асуулгын хуудас

Хүлээгдэх бүй ур дүн:

- Ажилтнууд төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгээ нэмэгдүүлэх
- Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлгогч, чадвар төлөвшинө
- Байгууллагын дотоод совл сайжирна

БОЛОВСРУУЛСАН: НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /Э.АРИУНЗУЛ/

Сургалтын гол үзүүлэлт:

№	Үзүүлэлт	Үнэлгээ
1	Төрийн албаны ёс зүйн тест /20 асуултай тест/	20 оноо
2	Практик дасгалыг 2 удаа амжилттай давтах (тохиолдолд суурилсан дасгал)	30 оноо
3	Төрийн албаны ёс зүйн дэд хорооны гишүүний үнэлгээ	30 оноо
4	Сургалтын орлцоо, ирц	20 оноо
	Нийт үнэлгээ	**100 оноо**

Бэлтгэл: Нэгдсэн эмнэлгийн сургалтын танхим, В1 давхрын сургалтын танхим

"Шинэ ажилтан бол байгууллагын ирээдүйг тодорхойлдог ур тариа - анхны сургалт нь хамгийн сайн бордоо юм"

БОЛОВСРУУЛСАН: НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /Э.АРИУНЗУЛ/

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН БҮРТГЭЛ

СУРГАЛТЫН САЛБАР

ТӨРИЙН АЛБАНЫ ЕС ЗҮЙ

СУРГАЛТ УДИРДСАН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР


НЭГ-ийн төрийн албаны ес зүй дэд хорооны дарга Д. Өлзийбаяр

Нарийн бичиг: Э. Ариунзул

Гишүүд: Х.Оюунбилэг, Т.Хулан

2025-05- 08

№	Овог нэрий үсэг, нэр	Тасаг, нэгж	Албан тушаал	Гарын үсэг
1	Ч. Дэлгэрмаа	ЭЗТ	асрагч	
2	Д. Пагмадулам	ЭЗТ	асрагч	
3	Б. Энхтуяа	ЭЗТ	асрагч	
4	Ж. Нарантуяа	ЭЗТ	сувилагч	
5	Л. Нарантуяа	ЭЗТ	асрагч	
6	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
7	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
8	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
9	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
10	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
11	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
12	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
13	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
14	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
15	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
16	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
17	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
18	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
19	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
20	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
21	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
22	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
23	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
24	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
25	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	
26	Ц. Мөнхзаяа	ЭЗТ	асрагч	



